



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2010 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
байгуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.3-ийн "ж" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2010 оны 1/3158 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийн асуудлыг хариуцан гүйцэтгүүлэхээр Сонгинохайрхан дүүрэгт "Хүнс хангамж төв" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулсугай.

Хоёр. "Хүнс хангамж төв" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын бүтэц орон тоо, дүрмийг баталж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Г.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.

Гурав. "Хүнс хангамж төв" нийслэлийн өмчит үйлдвэрийн газар байгуулагдсантай холбогдуулан "Асгат" нийслэлийн өмчит үйлдвэрийн газраар Баянгол дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийн асуудлыг хариуцан гүйцэтгүүлсүгэй.

Дөрөв. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 154 дүгээр тогтоолын 1 дэх заалтын "... Баянгол, Сонгинохайрхан дүүргийн дунд "Асгат" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг..." гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Т.БИЛЭГТ